



# ЗООНОЗЫН ӨВЧИН СУДЛАЛЫН ТӨВ

## Өмнөговь аймаг

ЗӨСТ нь байгалийн голомтот болон зоонозын халдварт өвчний эрсдэлт хүчин зүйлийг тандан судлах, хянах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, лабораторийн тусламж үйлчилгээ үзүүлэх, зоонозын хүний өвчлөлийн, тохиолдол дэгдэлтийн үеийн эрт сэрэмжлүүлэх хариу арга хэмжээг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажилладаг.

Түүхэн замнал

---

Алсын хараа  
Эрхэм зорилго

---

Хамт олон

---

**ХАЯГ:**

Өмнөговь аймаг,  
Даланзадгад сум

## Түүхэн замнал

ГАХӨЭСГазрын шинжилгээний отряд 1971 оны 09 дүгээр сараас эхлэн Өмнөговь аймгийн Гурвансайханы нурууны Зүүнсайханд тарваган тахлын голомтыг анх илрүүлжээ. Эндээс нийтдээ 6040 мэрэгчид, 12538 ширхэг бүүрэг, 19599 хачиг олзворлон шинжилсний дүнд 25000 га талбайг хамарсан тарваган тахлын эпизоотыг тогтоожээ. ГАХӨЭСГазрын мэргэжилтнүүдийн Гурвансайханд хийсэн шинжилгээний дүнд 1971 онд 7, 1972 онд 14, 1973 онд 5, 1974 онд 6, 1978 онд 3, 1979 онд 1, 1980 онд 7 бүгд тарваган тахлын 43 өсгөвөрийг илрүүлсэн байна. 1977 онд О.Мөнхтуяа Өмнөговь аймагт зурамны зэмнээс листериозын өсгөвөр ялгасан байна. ГАХӨЭСГазрын отряд шинжилгээний багт Пүрэвжал, Цэвэлмаа, Жигмэд, Гоогормаа, Адъяасүрэн, Ажиндай, Баваасан, лаборант Буянбадрах нарын алтан үеийн буурлууд маань ажиллаж байжээ.

Байгалийн голомтонд хийсэн шинжилгээний дүнгээр Говь Гурвансайханы тарваган тахлын голомтыг тогтоож, улмаар ГАХӨЭС станц байгуулах болсон байна.

БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн Гоц халдварт өвчнөөс сэргийлэх арга хэмжээг хүчтэй болгох тухай 1980 оны 78 дугаар тогтоолоор Өмнөговь аймагт ГАХӨЭС Станцыг 12 хүний орон тоотойгоор их эмч Гүнсэнгийн Цэрэндорж удирдан шинээр байгуулсан. Өмнөговь аймгийн ГАХӨЭС Станц нь Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн байгалийн голомтонд шинжилгээ судалгаа явуулах, хяналт тавих үүргийг хавсран гүйцэтгэж байв.

Тус аймгийн ГАХӨЭС Станц нь Далангийн эхэнд Ханхонгор сумын бага сургууль байсан барилгыг хүлээн авч засвар хийн ГАХӨЭС Станц байгуулагдан орсон түүхтэй.

Анх байгуулагдахад Станцын дарга Г. Цэрэндорж, нян судлалын лаборантаар Оюунбат, шимэгч судлалын лаборантаар Оюун, амьтан судлалын лаборантаар Сүхээ, голомтын сувилагч Диваахүү, үйлчлэгч Маам, амьтан маллагчаар Аюурзана, бэлтгэмэлчээр Гэрэлмаа, анчин Батцэнгэл, Баатарчулуун, Батмөнх, жолооч Ням-Осор, ариутгагч Долгорсүрэн, аж ахуй Шатар нар хамтран ажиллаж байсан түүхтэй.

ЭХЯамны сайдын А 1165 тоот тушаалаар ГАХӨЭСГазрыг БГХӨЭСТөв, аймаг хотын АЦХССтанцын ГАХӨвчний хяналтын тасгийг БГХӨТГазар болгон өөрчлөх шийдвэр гарсан. Манай аймагт энэ шийдвэрийг 1991 оны 2 дугаар сард хэрэгжүүлэн БГХӨТГазрын даргаар Г.Цэрэндорж томилогдон ажилласан. Д.Алтанчимэг нь 1992 оны 5 дугаар сараас БГХӨТГазрын дарга, 2012 оноос өнөөг хүртэл ЗӨСТөвийн даргаар ажиллаж байна.

2012 оны Засгийн газрын 231-р тогтоол, ЭМС-ын 2012 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 271-р тушаалаар “Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх алба”-ыг “Зоонозын өвчин судлалын төв” болгон өөрчлөгдөж шинэ дүрэм бүтцийг баталсан. Одоо Зоонозын өвчин судлалын төв нэртэй, 3 тасагтай, 13 ажилтантай үйл ажиллагаагаа явуулж байна. Байгууллагын нийт ажиллагсдын 53,8% нь дээд боловсролтой, 30,8% нь тусгай дунд мэргэжилтэй, 15,4 % нь бүрэн дунд боловсролтой ажилтнууд ажиллаж байна.

## Алсын хараа

Эрсдэлгүй орчин - Эрүүл мэнд

## Эрхэм зорилго

Зоонозын халдварт өвчний эрсдэлгүй орчныг бүрдүүлэн дэвшилтэд технологи нэвтрүүлэх замаар хүний өвчлөл эндэгдлийг бууруулана.

## Хамт олон



# Бидний бахархал

## ТӨРИЙН ОДОН МЕДАЛЬТНУУД

### Алтан гадас одонт

- Г. Цэрэндорж
- Б. Пүрэвжав
- Б. Цэцэгсүрэн
- Д. Алтанчимэг

### Хөдөлмөрийн хүндэт медальт

- Д. Алтанчимэг төвийн дарга 2007 он
- Д. Наранцэцэг шимэгч судлалын лаборант 2017 он

### Эрүүлийг хамгаалахын тэргүүний ажилтан цол тэмдэгтэн

- Х. Дүгэр нян судлалын лаборант 2000 он
- Д. Алтанчимэг төвийн дарга 2000 он
- Д. Наранцэцэг шимэгч судлалын лаборант 2008 он
- С. Оюунчимэг ариутгагч 2008 он
- С. Оюунсүрэн голомтын сувилагч 2008 он
- Г. Шүрэнцэцэг шимэгч судлагч 2012 онд
- Д. Сугир амьтан судлалын лаборант 2010 он
- З. Болд дүн бүртгэгч нярав 2015 он
- Ц. Амарзаяа нян судлалын лаборант 2014 он
- Д. Мөнхтөр жолооч 2012 он
- Ш. Оюунтуяа амьтан судлагч 2017 он
- Б.Оюунцэцэг амьтан судлагч 2017 он

### Банк санхүүгийн тэргүүний ажилтан

- Ш.Түмэнцэцэг 2012 он

### Соёлын тэргүүний ажилтан

- П. Мөнхбаатар жолооч 2012 он

### ЭМЯамны Жуух бичигтэн

- А.Цэвэгмэд дүн бүртгэгч, нярав 2002 он
- Н.Мөнхтогоо нян судлалын лаборант 2004
- Д.Наранцэцэг шимэгч судлалын лаборант 2005 он
- Б.Оюунцэцэг амьтан судлагч 2005 он
- С.Оюунчимэг ариутгагч 2005 он
- З.Болд дүн бүртгэгч нярав 2005 он
- Д.Сугир амьтан судлалын лаборант 2006 он
- Д. Мөнхтөр жолооч 2006 он
- Г.Шүрэнцэцэг шимэгч судлагч 2006 он
- Ц.Амарзаяа нян судлалын лаборант 2006 он
- Б.Баянмөнх жолооч 2010 он
- Ш. Оюунтуяа амьтан судлагч 2010 он.
- Т. Насанжаргал шил угаагч, үйлчлэгч 2012 он